

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	III
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ .....	IV
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	VI
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	VII
УДИРТГАЛ .....	1
НЭГ. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ .....	4
1.1. Хууль зүйн туслалцааны төвөөс үйлчилгээ авсан иргэн, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, үнэлгээ	4
1.2. Хууль зүйн туслалцааны төв болон улсын өмгөөлөгчийн хууль заасан чиг үүргээ хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд өгсөн хамтын ажиллагаа бүхий байгууллагын үнэлгээ .....	12
ХОЁР. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРЭГ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ .....	18
2.1. Хууль зүйн туслалцааны хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангасан байдал .....	18
2.2. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг нийтэд сурталчилж, таниулсан байдал .....	20
2.3. Хууль зүйн туслалцааны төвийн гадаад, дотоод хамтын ажиллагаа, санхүүжилт, бусад байгууллагын оролцоо .....	24
ГУРАВ. УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ .....	26
3.1. Улсын өмгөөлөгчийн ажиллах орчин нөхцөл .....	26
3.2. Улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал ба тохирсон цалин хөлс .....	31
3.3. Улсын өмгөөлөгчийн мэргэшүүлэх сургалт .....	33
ДҮГНЭЛТ .....	38
ЗӨВЛӨМЖ .....	40



# ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨВ



# ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

2022

Улаанбаатар хот  
2022 он

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МӨХ	Монголын Өмгөөлөгчдийн холбоо
МҮОНРТ	Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
МХХ	Монголын Хуульчдын холбоо
ТББ	Төрийн бус байгууллага
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗТТ	Хууль зүйн туслалцааны төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
IDLO	International Development Law Organization
ILF	International Legal Foundation

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн байршил .....	4
График 2. Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн нас, хүйс .....	4
График 3. Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн ажил эрхлэлт, боловсролын түвшин .....	5
График 4. Хууль зүйн туслалцааны төвөөс үйлчилгээ авсан давтамж .....	5
График 5. ХЗТТ-өөс өмгөөллийн үйлчилгээ авахын тулд хангах шаардлагын талаарх мэдлэг .....	6
График 6. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчдийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийг олж авсан эх сурвалж .....	6
График 7. Хууль зүйн туслалцааны төвийн цахим хуудсанд зочилж байсан эсэх .....	7
График 8. Хэрэв "Тийм" бол хэрэгтэй мэдээллээ авч чадсан уу? .....	7
График 9. Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааны зарчмыг үнэлж буй байдал.....	7
График 10. Хууль зүйн туслалцааны төвөөр үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл гарч байсан эсэх.....	8
График 11. ХЗТТ-өөр үйлчлүүлэхэд гарч буй хүндрэлүүд .....	8
График 12. Өмгөөллийн үйлчилгээг авч эхэлсэн үе шат /Өмгөөлүүлэх эрхээ эртнээс эдлэх боломж байсан эсэх/ .....	9
График 13. Танд мөрдөгчтэй нүүр тулан уулзах, мэдүүлэг өгөхөөсөө өмнө өмгөөлөгчтэй зөвлөлдөх боломж байдаг эсэх .....	9
График 14. Хэрэв мэдүүлэг өгсний дараа өмгөөлөгчтэй болсон бол анхны мэдүүлгээ өмгөөлөгчийг байлцуулан өгөх боломж байдаг эсэх .....	9
График 15. Танд өмгөөлөгчдийн зүгээс дараах хууль бус үйл ажиллагаа, дарамт шахалт үзүүлж байсан уу? .....	10
График 16. График. Улсын өмгөөлөгч таны санаа бодол, санал хүсэлтийг сонсож, анхаарч ханддаг эсэх .....	10
График 17. Үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн шуурхай байдлын үнэлгээ .....	11
График 18. Үйлчилгээний орчин, нөхцөл, мэдээллийн ил тод байдалд өгч буй үнэлгээ.....	11
График 19. Судалгаанд оролцогчдын байршил, эрхэлж буй ажил .....	12
График 20. Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран ажиллаж байсан туршлага бий эсэх .....	12
График 21. Хууль зүйн туслалцааны төвийн зарим чиг үүргийг үнэлж буй байдал .....	13
График 22. Тухайн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн ХЗТТ-ийн талаарх мэдлэг, мэдээллийг үнэлж буй байдал.....	13
График 23. Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн талаар мэдээлэл авсан эсэх .....	14
График 24. Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн талаарх байр суурь..	14
График 25. Улсын өмгөөлөгчийн ажлыг дүгнэж буй байдал.....	15
График 26. Улсын өмгөөлөгчийн ажлын ачааллын талаарх байр суурь .....	15
График 27. Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээнд өгч буй үнэлгээ .....	16
График 28. Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний орчин нөхцөлийн үнэлгээ .....	17
График 29. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчдийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийг олж авсан эх сурвалж .....	21
График 30. ХЗТТ-ийн цахим хуудсанд зочилж байсан эсэх .....	22
График 31. Хэрэв "Тийм" бол хэрэгтэй мэдээллээ авч чадсан уу? .....	22
График 32. Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн талаарх байр суурь..	23
График 33. Тухайн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн ХЗТТ-ийн талаарх мэдлэг, мэдээллийг үнэлж буй байдал.....	23
График 34. Улсын өмгөөлөгчөөр ажиллахад тулгарч буй гол бэрхшээл .....	28
График 35. Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлд заасан Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй байдлын үнэлгээ .....	29
График 36. Улсын өмгөөлөгч өөрийн ажлын ачааллаа үнэлсэн байдал.....	32
График 37. Долоо хоногт ажлын шаардлагаар ажил дээрээ оройтох болон илүү цагаар ажилладаг давтамж .....	32
График 38. Өөрийн хийж байгаа ажилдаа тохирохуйц цалин хөлс авдаг эсэх .....	33
График 39. Хүсэж буй цалингийн хэмжээ .....	33
График 40. Улсын өмгөөлөгчийн мэргэшсэн салбар эрх зүй.....	34

График 41. Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг ханган ажиллахад бэлэн эсэх .....	34
График 42. Улсын өмгөөлөгчөөс иргэний болон захиргааны хэрэгт ажилласан эсэх (Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/ үйлчилсэн хугацаанаас хойш) .....	35
График 43. Эрх зүйн салбараар мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамрагдах хэрэгцээ, шаардлага байгаа эсэх .....	35
График 44. Хууль зүйн туслалцааны төвөөс явуулдаг Улсын өмгөөлөгчийг чадавхжуулах сургалтын чанар, үр өгөөжийн үнэлгээ .....	36
График 45. Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл .....	36

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Анкетын аргаар цуглуулах мэдээллийн түүврийн хэмжээ .....	2
Хүснэгт 2. Ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан тоо.....	3

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Хууль зүйн туслалцааны төвийн Дархан-Уул аймаг дахь салбар (Буян захад байрлах) .....	30
Зураг 2. Хууль зүйн туслалцааны төвийн Сэлэнгэ аймаг дахь салбар (Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын засаг даргын тамгын газарт байрлах).....	30

## УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын иргэн нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах ... эрхтэй” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүрэгтэй” гэж, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” гэж тус тус заасан нь хууль зүйн туслалцааны суурь хэм хэмжээг бэхжүүлсэн. Мөн Монгол Улс 1974 онд нэгдэн орсон НҮБ-ын “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “d”-д “... өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, ... өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх” гэж заасан. Үндсэн хууль, олон улсын гэрээнд заасны дагуу “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-ийг 2013 онд баталж, зөвхөн эрүүгийн хэргийн яллагдагчаар хязгаарлан хууль зүйн туслалцаа үзүүлж ирсэн нь олон улсын туршлага, тухайн хуулийн хэрэгжилтийн явцад гарсан хуулийн үйлчлэлийн хүрээг өргөтгөн зохицуулах, эрх зүйн харилцаанд иргэн, захиргааны зарим хэрэг, маргаанд оролцогч төлбөрийн чадваргүй хүн, зарим зорилгот бүлгийн иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх шаардлагатайг тодотгон, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 онд батлан, 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж, мөрдсөнтэй холбогдуулан “Эрдэм сургалт судалгааны хүрээлэн” ТББ-аас Хууль зүйн туслалцааны төвийн хэрэглэгчийн үнэлгээг 3 бүлэгт хуваан судлан гүйцэтгэж, дүгнэлт зөвлөмж боловсруулсныг хүргэж байна.

### **Зорилго болон гарах үр дүн**

Мониторингийн судалгааны зорилго нь Хууль зүйн туслалцааны төвийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд үйлчилгээ авч буй төлбөрийн чадваргүй нэхэмжлэгч, хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтны санаа бодол, тухайлбал хэрэглэгчийн үнэлгээ, сэтгэл ханамж, хүлээлтийг тодорхойлж, тус үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжилтийг хангах, түүнд тулгарч буй сөрөг хүчин зүйлсийг даван туулахад чиглэсэн санал, зөвлөмж, нөлөөллийн саналыг боловсруулан гаргана.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

- a) Хууль зүйн туслалцааны төвийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин, үнэлгээг тодорхойлох, ингэхдээ үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдээр нарийвчлан гаргах;
- b) Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн мэдлэг, хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, түүний үр нөлөөг тодорхойлох;
- c) Үйл ажиллагааны талаарх олон нийтийн дэмжлэг, нийгэм сэтгэл зүйн таатай уур амьсгал бий болгож ажиллах чиглэлээр санал зөвлөмж, нөлөөллийн саналыг боловсруулах.

Хүлээгдэж буй үр дүн

- a) Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ бий болно.
- b) Хууль зүйн туслалцааны төвийн хуулиар хүлээсэн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлд ач холбогдол бүхий дүгнэлт, зөвлөмж, нөлөөллийн санал боловсруулагдан гарна.
- c) Олон нийтэд судалгааны гол үр дүнгийн талаар хэлэлцүүлэг, танилцуулга



хийгдэх боломжтой болно.

### **Мониторингийн аргачлал**

Мониторингийн судалгаагаар тоон (анкет) болон чанарын (ганцаарчилсан ярилцлага, баримт бичгийн шинжилгээ) судалгааны загвар, арга зүйг хавсран хэрэглэнэ. Судалгааны зорилтуудад тусгасан үндсэн болон нарийвчилсан асуултад хэрхэн хариулт авахыг арга хэрэгсэл тус бүрээр доорх байдлаар харуулж байна.

Анкетын арга: Анкетын арга нь олон нийтийн санаа бодол, хүсэл эрмэлзэл, хандлага, үнэлгээг тодорхойлоход хамгийн тохиромжтой мэдээлэл цуглуулах үндсэн арга билээ. Тиймээс энэхүү судалгаанд анкетын аргаар Хууль зүйн туслалцааны төвийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх төлбөрийн чадваргүй нэхэмжлэгч, хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтны болон хамтын ажиллагаа бүхий Цагдаагийн ерөнхий газрын (цаашид ЦЕГ гэх), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын (цаашид ШШГЕГ гэх), мөн шүүгчдийн төлөөллийг хамруулан мэдээлэл цуглуулна.

Судалгаанд нийт 3 төрлийн анкетын асуулга хэрэглэсэн. Үүнд:

- Үйлчилгээ авсан төлбөрийн чадваргүй нэхэмжлэгч, хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтнаас мэдээлэл цуглуулах анкет;
- Хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллөөс мэдээлэл цуглуулах анкет;
- Улсын өмгөөлөгчөөс мэдээлэл цуглуулах анкет;

Анкетын судалгааны мэдээллийг PAPI буюу нүүр тулсан (Paper and Pen Interviewing) болон CAPI буюу цахим (Computer-assisted program interviewing) хэлбэрээр авах бөгөөд анкетын судалгааны явцад илэрсэн онцлог кейс бүхий, үнэ цэнтэй мэдээлэл өгөх респонденттэй ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулна.

Ганцаарчилсан ярилцлагын арга: Ганцаарчилсан ярилцлагын арга нь анкетын аргаар авсан мэдээллийн учир шалтгаан, мөн чанар, дотоод зүй тогтлыг илэрхийлэн гаргахад ихээхэн үр дүнтэй байдаг. Тиймээс энэхүү судалгаанд ганцаарчилсан ярилцлагын аргаар анкетын судалгааны мэдээллийг гүнзгийрүүлэн шалгах, учир шалтгааныг нь тодорхойлох мэдээллийг цуглуулна. Дараах субъектээс ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулна. Үүнд:

- Төлбөрийн чадваргүй нэхэмжлэгч, хариуцагч
- Төлбөрийн чадваргүй сэжигтэн;
- Төлбөрийн чадваргүй шүүгдэгч;
- Шүүгч;
- ШШГЕГ-ын холбогдох төлөөлөл;
- ЦЕГ-ын холбогдох төлөөлөл;

Баримт бичгийн шинжилгээний арга: Энэхүү судалгаанд холбогдох баримт бичгийг дараах ангилалд оруулан шинжилгээ хийхээр төлөвлөсөн болно. Үүнд:

- Хууль зүйн туслалцааны төвийн хэрэгжүүлсэн арга хэмжээ, тушаал, шийдвэр зэргийг агуулсан холбогдох баримт бичиг, тайлан, өргөдөл гомдолд шинжилгээ хийх;
- Судалгаанд холбогдох статистик, тоо, мэдээ, үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийх;

Түүврийн нарийвчлал

*Хүснэгт 1. Анкетын аргаар цуглуулах мэдээллийн түүврийн хэмжээ*

№	Мэдээлэл авах	Түүврийн хэмжээ
---	---------------	-----------------

1	Үйлчилгээ авсан төлбөрийн чадваргүй нэхэмжлэгч, хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтнаас мэдээлэл цуглуулах анкет	150
2	Хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллөөс мэдээлэл цуглуулах анкет	100
3	Улсын өмгөөлөгчөөс мэдээлэл цуглуулах анкет	Нэлэнхий
4	Нийт	250

*Хүснэгт 2. Ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан тоо*

№	Ярилцлага хийх субъект	Ганцаарчилсан ярилцлагын тоо
1	Төлбөрийн чадваргүй сэжигтэн	2
2	Төлбөрийн чадваргүй шүүгдэгч	2
3	Төлбөрийн чадваргүй нэхэмжлэгч	2
4	Төлбөрийн чадваргүй хариуцагч	2
5	Улсын өмгөөлөгч	4
6	Шүүгч	2
7	ШШГЕГ-ын холбогдох төлөөлөл	2
8	ЦЕГ-ын холбогдох төлөөлөл	2
9	Прокурор	2
	Нийт	20

**Мониторингийн хамрах хүрээ**

Улаанбаатар хотын 2 дүүрэг болон бусад орон нутгаас 2 аймгийн улсын өмгөөлөгчдийг хамаарах бүс нутгийг газарзүйн байрлал, нийгэм, хүн ам зүйн үзүүлэлтэд тулгуурлан сонгохоор төлөвлөсний дагуу Сэлэнгэ, Дархан аймаг болон нийслэлийн Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Хууль зүйн туслалцааны төвийн салбаруудыг сонгов. ХЗТТ-өөр үйлчлүүлэгч иргэдийн хувьд хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ авсан иргэд болон Цагдан хорих 461 дүгээр ангид буй үйлчлүүлэгчдийг хамруулав.


## НЭГ. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны энэ хэсэгт ХЗТТ-өөр үйлчлүүлэгчид болон хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллөөс авсан анкетын судалгааны үр дүнд үндэслэн ХЗТТ-ийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх юм. Тус байгууллагаас үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийг хууль зүйн зөвлөгөө авсан иргэд болон өмгөөллийн үйлчилгээ авсан иргэд гэсэн хоёр үндсэн хэсэгт ангилан, ангилал тус бүрийн үр дүнг хооронд нь харьцуулан авч үзэх бол хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллийн эрхэлж буй ажил мэргэжлээр нь харьцуулан үр дүнг танилцуулах болно.

### 1.1. Хууль зүйн туслалцааны төвөөс үйлчилгээ авсан иргэн, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, үнэлгээ


Үйлчилгээ авсан иргэн, үйлчлүүлэгчээс цаасаар болон утсаар холбогдож судалгааны мэдээллийг цуглуулсан бөгөөд нийт 152 иргэн, үйлчлүүлэгчийн мэдээллийг нэгтгэн үр дүнг танилцуулж байна.

*График 1. Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн байршил*




Судалгаанд хамрагдсан иргэдийн 78 хувь нь орон нутгаас, 3 хувь нь нийслэлээс, 19 хувь нь ШШГЕГ-ын харьяа хорих 461 дүгээр ангиас хамрагдсан байна.

*График 2. Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн нас, хүйс*




Судалгаанд хамрагдсан ХЗТТ-өөр үйлчлүүлсэн иргэдийн дийлэнх нь буюу 39.3 хувь нь 18-30 насныхан байгаа бол 24.3 хувь нь 31-40 насныхан байна. Харин 61 ба түүнээс дээш насны үйлчлүүлэгч 3.7 хувийг эзэлж байна. Мөн судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн хүйсийн харьцаа тэнцвэртэй буюу эмэгтэйчүүд 52 хувийг, эрэгтэйчүүд 48 хувийг эзэлж байна.

График 3. Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн ажил эрхлэлт, боловсролын түвшин




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 45.6 хувь нь ажил эрхэлдэггүй, 5.4 хувь нь тэтгэврийн насныхан, 6 хувь нь оюутан/сурагч, 2.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Боловсролын түвшний хувьд 34.7 хувь нь бүрэн дунд, 27.3 хувь нь бүрэн бус дунд, 20 хувь нь дээд боловсролтой байна.

График 4. Хууль зүйн туслалцааны төвөөс үйлчилгээ авсан давтамж



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн дийлэнх нь ХЗТТ-өөс анх удаа үйлчилгээ авч байна. Өмгөөллийн үйлчилгээ авсан иргэдийн 71.4 хувь нь, хууль зүйн зөвлөгөө авсан иргэдийн 74.6 хувь нь анх удаа үйлчилгээ авсан байна. Харин өмгөөллийн үйлчилгээ авсан иргэдийн 23.8 хувь буюу 5 үйлчлүүлэгч тутмын 1 нь 2-3 удаа үйлчилгээ авч байжээ. Хууль зүйн зөвлөгөө авсан иргэдийн хувьд 4 ба түүнээс дээш удаа зөвлөгөө авсан гэж 6.6 хувь нь хариулснаас үзвэл хууль зүйн зөвлөгөө авсан үйлчлүүлэгч дахин үйлчилгээ авах хүсэл сонирхол өндөр, тогтмол үйлчлүүлж байгааг харуулж байна.

График 5. ХЗТТ-өөс өмгөөллийн үйлчилгээ авахын тулд хангах шаардлагын талаарх мэдлэг



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн хувьд Хууль зүйн туслалцааны тухай хуулийн талаар бүрэн дүүрэн ойлголтгүй боловч өмгөөллийн үйлчилгээ авсан иргэдийн 85.2 хувь нь ХЗТТ-өөс өмгөөллийн үйлчилгээ авахын тулд төлбөрийн чадваргүй яллагдагч гэдгээ нотолсон байх ёстой гэж хариулснаас үзвэл ХЗТТ-өөс өмгөөллийн үйлчилгээ авахын тулд тодорхой хуулийн шаардлага хангах талаар мэдлэгтэй болох нь харагдаж байна.

График 6. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчдийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийг олж авсан эх сурвалж



Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчдийн 44.6 хувь нь танил тал, хүмүүсийн ярианаас ХЗТТ-ийн болон улсын өмгөөлөгчдийн үйлчилгээний талаар мэдээллийн олж авсан байна. Өөрөөр хэлбэл өмнө нь ХЗТТ-өөс үйлчилгээ авсан иргэд тус байгууллагын үйлчилгээг бусад шаардлагатай иргэдэд хүргэж буй мэдээллийн эх үүсвэр болж байна. Мөн үйлчилгээ авсан иргэд улсын өмгөөлөгчдийн үйлчилгээг бусдад санал болгож буй буюу үйлчилгээнд сэтгэл хангалуун үлдсэнийг харуулах үзүүлэлт юм. Хамтын ажиллагаа бүхий байгууллагаас мэдээлэл авч буй байдлыг харвал судалгаанд хамрагдсан иргэдийн 25 хувь буюу 4 үйлчлүүлэгч тутмын 1 нь анх цагдаагийн байгууллагаас ХЗТТ-ийн болон улсын өмгөөлөгчийн үйлчилгээний талаар мэдээлэл авсан байна. Прокуророос мэдээлэл авсан байдал хамгийн бага буюу 1.4 хувь нь прокуророос мэдээллийг олж авсан байна.

График 7. Хууль зүйн туслалцааны төвийн цахим хуудсанд зочилж байсан эсэх






График 8. Хэрэв "Тийм" бол хэрэгтэй мэдээллээ авч чадсан уу?




Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн 5.4 хувь нь ХЗТТ-ийн цахим хуудсанд зочилж байсан туршлагатай байна. Харин цахим хуудсанд зочилсноор хэрэгтэй мэдээллээ олж авч чадсан эсэхийг тодруулахад 29.4 хувь нь тийм гэж хариулсан байна. Иймд цахим хуудасны мэдээллийг иргэн, үйлчлүүлэгчид энгийн, ойлгомжтой хэлбэрээр байршуулах, түгээмэл асуулт, хариултын буланг хөгжүүлэх замаар цахим хуудаст зочилсон үйлчлүүлэгч бүр эрж, хайсан мэдээллээ олж авах боломжийг цаашид бүрдүүлэх шаардлагатай байна.

График 9. Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааны зарчмыг үнэлж буй байдал




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн дийлэнх нь улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааны зарчмын хэрэгжилтийг өндрөөр үнэлж байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 82.1 хувь нь нууцыг чанд хадгалдаг, 80.1 хувь нь шуурхай, бүрэн, тууштай байдаг, 78.8 хувь нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэдэг гэж үзсэн байна.

График 10. Хууль зүйн туслалцааны төвөөр үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл гарч байсан эсэх




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 9 хувь нь ХЗТТ-өөр үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл гарч байсан гэжээ. Үйлчилгээ авсан төрлөөр ангилан авч үзвэл өмгөөллийн үйлчилгээ авсан иргэдийн 43.5 хувь нь хүндрэл бэрхшээл учирсан гэж хариулсан бол хууль зүйн зөвлөгөө авсан иргэдийн 2.5 хувь нь хүндрэл бэрхшээл тулгарсан гэжээ. Үйлчилгээ авсан төрлөөс хамаарч хүндрэл бэрхшээл тохиолдох нь харилцан адилгүй байгааг дээрх үр дүнгээс харж болохоор байна. Өмгөөллийн үйлчилгээ авсан иргэдээс ямар хүндрэл бэрхшээл тулгарсныг тодруулахад сайн уулзаж ярилцаагүй, төлбөрийн чадваргүй гэж үздэг, өмгөөлөгч сэтгэлээсээ биш өнгө мөнгө хардаг зэрэг хариултыг өгсөн байна.

График 11. ХЗТТ-өөр үйлчлүүлэхэд гарч буй хүндрэлүүд



ХЗТТ-өөр үйлчлүүлэхэд тулгардаг бэрхшээлийг өмгөөллийн үйлчилгээ авсан иргэдийн хувьд 63.6 хувь нь өмгөөлөгчтэйгөө биечлэн уулзах боломж хомс, 22.7 хувь нь өмгөөлөгчтэйгөө утсаар ярих боломж муу байдаг гэжээ. Харин хууль зүйн зөвлөгөө авсан үйлчлүүлэгчдийн хувьд 81 хувь нь бичиг цаасны ажил, түүнийг хөөцөлдөх нь хүндрэлтэй гэсэн бол 11.4 хувь нь ХЗТТ-ийн байршил хол, цаг хугацаа алдах нь хүндрэлтэй байдаг гэжээ.

График 12. Өмгөөллийн үйлчилгээг авч эхэлсэн үе шат /Өмгөөлүүлэх эрхээ эртнээс эдлэх боломж байсан эсэх/



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 45.1 хувь нь цагдаад шалгагдаж байх үедээ өмгөөллийн үйлчилгээг авч эхэлсэн байна. Мөн 20.4 хувь нь гэмт хэрэг үйлдсэн даруйдаа өмгөөллийн үйлчилгээг авч эхэлснээс үзвэл өмгөөлүүлэх эрхээ эртнээс эдлэх боломжтой гэж үзэж болохоор байна.

График 13. Танд мөрдөгчтэй нүүр тулан уулзах, мэдүүлэг өгөхөөсөө өмнө өмгөөлөгчтэй зөвлөлдөх боломж байдаг эсэх





График 14. Хэрэв мэдүүлэг өгсний дараа өмгөөлөгчтэй болсон бол анхны мэдүүлгээ өмгөөлөгчийг байлцуулан өгөх боломж байдаг эсэх



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 85.7 хувь нь мөрдөгчтэй нүүр тулан уулзах, мэдүүлэг өгөхөөсөө өмнө өмгөөлөгчтэй зөвлөлдөх боломж байдаг гэсэн бол 39.5 хувь нь мэдүүлэг өгсний дараа өмгөөлөгчтэй болсон бол анхны мэдүүлгээ өмгөөлөгчийг байлцуулан өгөх боломж байдаг гэжээ. Мөн энэ талаар 54 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.



График 15. Танд өмгөөлөгчдийн зүгээс дараах хууль бус үйл ажиллагаа, дарамт шахалт үзүүлж байсан уу?





График 16. График. Улсын өмгөөлөгч таны санаа бодол, санал хүсэлтийг сонсож, анхаарч ханддаг эсэх



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 97.4 хувь нь улсын өмгөөлөгчийн зүгээс хууль бус үйл ажиллагаа, дарамт шахалт үзүүлж байгаагүй гэсэн бол 2 хувь нь ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ нуун дарагдуулах, 0.7 хувь нь төлбөр нэхэх зэргээр хууль бус үйл ажиллагаа явуулсан гэжээ. Мөн судалгаанд оролцогчдын 64.6 хувь нь улсын өмгөөлөгч санаа бодол, санал хүсэлтийг сонсож, анхаарч ханддаг гэж үзэж байгаа нь сайшаалтай байна.

#### Шигтгээ

Хорих ангид хоригдож байгаа сэжигтэн, яллагдагчийн хувьд хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээ эдлэх тун бэрхшээлтэй. Хорих ангийн нийгмийн ажилтан хууль зүйн туслалцааны төвд хандах өргөдлийн маягт өгч, маягтын дагуу өргөдөл гаргадаг ч, хариу нь хуулийн хугацаандаа ирдэггүй. Үүний улмаас өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй дахин дахин өргөдөл гаргаж, цаг хугацаа алддаг. Ер нь хорих ангид өмгөөлөгч эсхүл хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх аудио бичлэг байршуулбал олон хүнд хууль зүйн мэдлэг, ойлголт өгнө гэж бодож байна. Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний талаар хорих анги дотор орж ирээд л бие биеэсээ мэдэж өргөдөл гаргадаг. Өөртөө авсан үйлчилгээг үнэлбэл 1 оноогоор хангалтгүй гэж үнэлнэ.

Өмгөөллийн үйлчилгээ авсан иргэнтэй хийсэн ярилцлагаас


Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн зүгээс өмгөөлөгчтэй 7 хоног бүр эсхүл уулзах тогтмол хуваарьтай байх, орон тоог нь нэмэх, өрөөг нь тохижуулах, хүсэлтийн хариуг хугацаанд нь түргэн шуурхай ирүүлэх зэргээр үйлчилгээг сайжруулах саналыг чанарын судалгааны явцад онцолж байв.

График 17. Үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн шуурхай байдлын үнэлгээ



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчид ХЗТТ-ийн үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн шуурхай байдлыг өндрөөр үнэлж байна. Тухайлбал, үйлчилгээг хуулийн хугацаанд шуурхай үзүүлэх байдлыг 98 хувь нь, улсын өмгөөлөгчийн зан, харилцаа, ёс зүй, мэргэжлийн ур чадварыг 96.6 хувь нь, үйлчилгээг адил тэгш ялгаваргүй, бүрэн, тууштай үзүүлэх байдлыг 95.9 хувь нь, үйлчилгээний чанар, үр дүн, улсын өмгөөлөгчийн туршлагатай байдлыг 95.3 хувь нь, өмгөөлөгч үйлчилгээний талаар мэдээлэл өгөх байдлыг 93.9 хувь нь дунд, сайн гэж үнэлсэн байна. ХЗТТ-ийн үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн шуурхай байдалд өгч буй үнэлгээ нь дээрх 9 үзүүлэлтийн дунджаар 95.7 хувь байна.

График 18. Үйлчилгээний орчин, нөхцөл, мэдээллийн ил тод байдалд өгч буй үнэлгээ




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчид үйлчилгээний өрөө, танхимын орчин нөхцөл,

ая тухтай байдлыг 94.4 хувь нь, гаргасан санал хүсэлт, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэж хариу өгөх, арга хэмжээ авах байдлыг 92.9 хувь нь, хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг өөр хэлбэрээр авах боломж нөхцөлийг 92.3 хувь нь, зөвлөгөө, үйлчилгээтэй холбогдох асуудлаар санал, шүүмж, хүсэлт гаргах нөхцөл боломж нээлттэй байдлыг 91.6 хувь нь дунд, сайн гэж үнэлсэн байна. ХЗТТ-ийн үйлчилгээний орчин, нөхцөл, мэдээллийн ил тод байдалд өгч буй үнэлгээ нь дээрх 4 үзүүлэлтийн дунджаар 92.8 хувь байна.

### 1.2. Хууль зүйн туслалцааны төв болон улсын өмгөөлөгчийн хууль заасан чиг үүргээ хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд өгсөн хамтын ажиллагаа бүхий байгууллагын үнэлгээ


Хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллөөс нийт 100 ажилтан, албан хаагчийг хамруулсан бөгөөд мэдээллийг нэгтгэн үр дүнг танилцуулж байна.

График 19. Судалгаанд оролцогчдын байршил, эрхэлж буй ажил




Судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллийн 76.8 хувь нь орон нутгаас, 23.2 хувь нь нийслэлээс хамрагдсан байна. Мөн эрхэлж буй ажлын хувьд 33 хувь нь прокурор, 29 хувь нь мөрдөгч, 19 хувь нь шүүгчийн туслах, 14 хувь нь шийдвэр гүйцэтгэгч, 4 хувь нь шүүгч байна.

График 20. Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран ажиллаж байсан туршлага бий эсэх




Судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллийн 44.9 хувь нь өмнө нь ХЗТТ-тэй аливаа хэлбэрээр хамтран ажилласан туршлагатай байна.

График 21. Хууль зүйн туслалцааны төвийн зарим чиг үүргийг үнэлж буй байдал




Судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхийн байгууллагын төлөөлөл ХЗТТ-ийн улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах, түүнийг зохион байгуулах ажлыг 57.1 хувь нь, улсын өмгөөлөгчийн хуульчийн үргэлжилсэн сургалтыг зохион байгуулах ажлыг 55.1 хувь нь, хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг 53.3 хувь нь, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх байдлыг 56.2 хувь нь сайн, дунд гэж үнэлжээ. ХЗТТ-ийн зарим чиг үүрэгт өгч буй үнэлгээ нь дээрх 4 үзүүлэлтийн дунджаар 55.4 хувь байна.

График 22. Тухайн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн ХЗТТ-ийн талаарх мэдлэг, мэдээллийг үнэлж буй байдал




Хамтын ажиллагаа бүхий бусад байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн хувьд 27.4 хувь нь ХЗТТ-ийн талаар мэдлэг, мэдээлэл сайтай байна. Харин дийлэнх буюу 68.4 хувь нь мэдээлэл муу, 4.2 хувь нь буруу ташаа ойлголттой байна. Иймд хамтын ажиллагаа бүхий байгууллагаар дамжуулан олон нийтийн ХЗТТ-ийн чиг үүрэг, улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах нь зүйтэй байна.

График 23. Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн талаар мэдээлэл авсан эсэх




Судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллийн 51.5 хувь буюу 2 оролцогч тутмын 1 нь Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдээлэл авсан байна. Байгууллагаар ангилан авч үзвэл шүүхийн байгууллагаас оролцогчдын 63.2 хувь нь, цагдаагийн байгууллагаас оролцогчдын 57.1 хувь нь, ШШГЕГ-аас оролцогчдын 53.8 хувь нь мэдээлэл авсан байна. Харин прокурорын байгууллагаас оролцогчдын 35.7 хувь буюу бусад байгууллагатай харьцуулахад мэдээлэл авсан хувь бага байна.

График 24. Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн талаарх байр суурь




Судалгаанд хамрагдсан шүүх болон цагдаагийн байгууллагаас оролцогчид Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хангалттай сайн болсон гэж үзэж байна. Харин ШШГЕГ болон прокурорын байгууллагаас оролцогчид сайжруулах санал болгох зохицуулалт бий гэжээ. Цаашид тус байгууллагаас санал авах зэргээр тухайн сэдвээр нарийвчлан судалгаа хийх боломжтой байна.

График 25. Улсын өмгөөлөгчийн ажлыг дүгнэж буй байдал



Судалгаанд оролцогчдын 45.8 хувь нь улсын өмгөөлөгчид талархалтай ханддаг бол 44.8 хувь нь үйлчилгээний чанарт эргэлзээтэй ханддаг нь анхаарал татаж байна. Тухайлбал ШШГЕГ-аас оролцогчдын 85.7 хувь нь, цагдаагийн байгууллагаас оролцогчдын 57.1 хувь нь, прокуророос оролцогчдын 51.9 хувь нь үйлчилгээний чанарт эргэлзээтэй ханддаг гэж харилсан нь шүүхийн байгууллагаас оролцогчдоос өндөр хувьтай байна.

График 26. Улсын өмгөөлөгчийн ажлын ачааллын талаарх байр суурь



Судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллийн 25.8 хувь нь улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал их, 34 хувь нь тохирсон, хэвийн ачаалалтай гэж үзсэн бол 14.4 хувь ачаалал багатай гэж үзэж байна. Эндээс үзвэл хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллийн дийлэнх нь улсын өмгөөлөгчийн ажлын ачааллыг хэвийн гэж үзэж байна. Харин ШШГЕГ-аас оролцогчдын 35.7 хувь нь ачаалал их гэж үзсэн нь бусад байгууллагаас өндөр байгаа бол прокурорын байгууллагаас оролцогчдын 25 хувь нь ачаалал багатай гэж үзсэн нь бусад байгууллагатай харьцуулахад өндөр байна.


#### Шигтгээ

Улсын өмгөөлөгчийн ачаалал эхээс гадна ер бол олдохгүй талдаа нэг аймагт 1-2 өмгөөлөгч хаанаа ч хүрэлцдэггүй, олон холбогдогчтой хэрэгт өмгөөлүүлэх эрхийг хангах ямар ч боломж байхгүй, мөн орон нутагт өмгөөлөгч хүрэлцээгүйгээс болоод хувийн өмгөөлөгчийг гэрээгээр төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхийг хүссэн ч үйлчилгээ хангалтгүй байна. Заримдаа улсын өмгөөлөгч нь хувийн өмгөөлөгч хийгээд явж байх жишээтэй. Хуулиараа болно, болохгүйг нь заагаад өгчихсөн байхад энэ байж болох юм уу. Мөн засаг даргын тамгын газар, зарим газар нэг цэгийн үйлчилгээний

төвд улсын өмгөөлөгчид ажлын байр гаргаж өгөх юм угтаа бол цагдаагийн байгууллага дээр л тэр ажлын байр нь байж баймаар үйлчлүүлэгчдээ ойр, түргэн шуурхай хүртээмжтэй ажиллана гэвэл ажлын байрны байршил хүртэл чухал юм. Үүнийг мөн анхааралдаа аваасай гэж бодож байна.


Хамтын ажиллагаатай байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

График 27. Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээнд өгч буй үнэлгээ



Судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөлөл үйлчилгээг хуулийн хугацаанд шуурхай үзүүлэх байдлыг 65.9 хувь нь, үйлчилгээг адил тэгш ялгаваргүй үзүүлэх байдлыг 65.1 хувь нь, үйлчилгээг бүрэн, тууштай үзүүлэх байдлыг 69.4 хувь нь, үйлчилгээний чанар, үр дүнг 63.7 хувь нь, улсын өмгөөлөгчийн зан, харилцаа, ёс зүйг 67 хувь нь, улсын өмгөөлөгчийн туршлагатай байдлыг 71.6 хувь нь, улсын өмгөөлөгчийн мэргэжлийн ур чадварыг 68.3 хувь нь, өмгөөлөгч үйл ажиллагааны талаар хариу мэдээлдэг, эргэж холбогдох байдлыг 61.6 хувь нь, өмгөөлөгч үйлчилгээний талаар мэдээллийг хангалттай өгөх байдлыг /олон дахин ирж очуулахгүй байдал/ 63.2 хувь нь дунд, сайн гэж үнэлсэн байна. ХЗТТ-ийн үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн шуурхай байдалд өгч буй үнэлгээ нь дээрх 9 үзүүлэлтийн дунджаар 66.2 хувь байна.

График 28. Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний орчин нөхцөлийн үнэлгээ



Судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөлөл үйлчилгээний өрөө, танхимын /ширээ, сандлын хүрэлцээ/ нөхцөл, ая тухтай байдлыг 82.9 хувь нь, хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг өөр хэлбэрээр авах боломж нөхцөлийг /мэдээллийн самбар, гарын авлага г.м/ 69.6 хувь нь, гаргасан санал хүсэлт, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэж хариу өгөх, арга хэмжээ авах байдлыг 85.2 хувь нь дунд, сайн гэж үнэлсэн байна. ХЗТТ-ийн үйлчилгээний орчин, нөхцөл, мэдээллийн ил тод байдалд өгч буй үнэлгээ нь дээрх 3 үзүүлэлтийн дунджаар 79.2 хувь байна.

#### Шигтгээ

Хорих ангид байгаа хоригдогч (сэжигтэн, яллагдагч) хууль зүйн туслалцааны төвд өргөдөл гаргадаг хэдий ч ихэнх өргөдлийн хариу ирдэггүй, мөн хугацаандаа ирдэггүйн улмаас дахин өргөдөл гаргаж цаг хугацаа алддаг. Хууль зүйн туслалцааны төвөөс манай байгууллагын тоо бүртгэлтэй тулгалт хийж, өргөдлийн хариуг өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй авах боломжтой боломжгүй гэсэн хариуг хурдан өгдөг болмоор, байгаа юм. Манай байгууллага хоригдолд чиглэсэн сургалтыг төлөвлөгөөний дагуу хийдэг бол хоригдогчид чиглэсэн зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ хомс, Хууль зүйн туслалцааны төвөөс ирүүлсэн маягтыг бүрэн бөглүүлж, өмгөөллийн үйлчилгээ авах талаар уламжлах хүрээнд л туслалцаа үзүүлж ажиллаж байна. Харин өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээр ирсэн өмгөөлөгч нарт үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах байр гаргаж өгсөн ч мөн л хүрээгүй хэвээр байгааг ангийн удирдлагад уламжлан шийдвэрлүүлэхээ-р ажиллаж байгаа. Хамтын ажиллагаатай байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллийн зүгээс ХЗТТ-ийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчийн үйлчилгээ сайжруулах хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх
- Улсын өмгөөлөгчийн мэргэшсэн чиглэлээр ажиллуулах
- Үйлчилгээ олон нийтэд мэдээлэл хүргэх дамжуулах
- Нээлтэй ил тод мэдээллээр хангах
- Улсын өмгөөлөгчийн орон тоог нэмэх
- Өмгөөлөгчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх
- Мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад идэвхтэй хамруулах
- Танилцуулга сурталчилгаа хийх
- Цагдаагийн газар дээр байрлаж ажилладаг болгох
- Цахим мэдээлэл олгох зэрэг саналыг дэвшүүлсэн байна.



## **ХОЁР. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРЭГ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

### **2.1. Хууль зүйн туслалцааны хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангасан байдал**

Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн хүний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх хүрээ, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтоох зорилтын хүрээнд Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг батлан, 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт Хууль зүйн туслалцааны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гэж хуульчилсан.

Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга), дүрэм журмын хэрэгжилтийг хангасан байдалд хангах хүрээнд тус хуулийг дагаж гарах дүрэм, журмыг боловсруулах, батлан гаргах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, Төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан болон холбогдох мэдээлэлд үндэслэн үнэлгээ хийлээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/71 тоот тушаалаар Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдөр хуралдан Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж гарах дүрэм журмыг боловсруулах ажлын хүрээнд хэм хэмжээ тогтоосон журмын төлөвлөгөөг өөрчлөн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж батлуулсан төлөвлөгөөний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/343 тоот тушаалаар “Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-ний загвар, “Хувийн өмгөөлөгчтэй байгуулах гэрээ”-ний загвар, “Өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх хувийн өмгөөлөгчтэй байгуулах гэрээ”-ний загвар, “Хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэр”-ийн загварыг тус тус батлуулжээ.

Хууль зүйн туслалцааны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Хууль зүйн туслалцааны төвийн дүрэм”, “Улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах журам”, “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, “Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх журам”, “Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх журам”, “Хууль зүйн туслалцааны мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хамгаалах, мэдээлэл солилцох журам”-ын төслийг тус тус боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлжээ.

Мөн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгчтэй хамтран батлах “Хувийн өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж, Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд хүргүүлжээ.

2022 онд шинээр батлагдан хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхэлсэн бусад хууль тогтоомжийг биелүүлэх, хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга) 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болж дагаж мөрдсөнтэй холбогдуулан Төвийн төрийн үйлчилгээний албан хаагчидтай байгуулах “Хөдөлмөрийн гэрээ” болон “Хөлсөөр ажиллах гэрээ”-г шинэчлэн боловсруулж, үйлчилгээний албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээг дахин байгуулж, баталгаажуулсан.

2. Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга) дагаж мөрдөж эхэлсэн, Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдсантай холбогдуулан Хууль зүйн туслалцааны төвийн захирлын 2022 оны А/24 дугаар тушаалаар Төвийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ийн шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

*Өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байдал*

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэгт “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэж заасан. Мөн 1995 онд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг баталсан нь өргөдөл гомдол гаргагчийн эрх, түүнийг хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн.

Хууль зүйн туслалцааны төвд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж, тодорхой арга хэмжээ авч ажилладаг.

Төвд 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар хууль зүйн туслалцаа хүссэн өргөдөл 2531, хүний нөөцийн асуудлаар /ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх тухай/ гаргасан өргөдөл 65, улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн гомдол 6, нийт 2596 өргөдөл, 6 гомдол, 4 хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж хариу өгчээ.

Төвд хандан иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 2596 өргөдлийн 2531 буюу 96.4 хувь нь хууль зүйн туслалцаа хүссэн агуулга бүхий өргөдөл, 6 буюу 0.2 хувь нь улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл ирсэн байна.

*Улсын өмгөөлөгчийн эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил*

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 5 дугаар зүйлийн 5.1.3-т эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх ажлыг хууль зүйн туслалцааны төрөлд оруулан хуульчилсан нь Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилт 3-т Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд бүх талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна. Мөн зорилтын 3.3.2-т эрх зүйн болон хүний эрхийн сургалт, сурталчилгаанд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, Хууль зүйн туслалцааны төвийн орон нутаг дахь салбар болон бусад холбогдох этгээдийн оролцоог нэмэгдүүлэх гэж, Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дөрөв. Засаглалын бодлого, 4.4.9-т Хууль тогтоомжийн төсөл санаачлах хүрээ, хязгаарыг тодорхойлж, хуулийн төслийн боловсруулалтын чанарын үр нөлөөг дээшлүүлж, хуулийн хэрэгжилтийг үнэлэх, хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах байнгын механизмыг бүрдүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.5-ын хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн, I үе шат (2021-2030): Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх гэж үечлэн хууль тогтоомжид тусгасныг хууль зүйн туслалцааны төв хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн талаараа тайландаа дурджээ.

**Шигтгээ**

Хуулийн шинэчилсэн найруулгаар хууль зүйн туслалцааны төрөлд Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх ажил улсын өмгөөлөгч нарт нэмэгдсэн. Бид хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахын тулд зохих түвшинд төлөвлөн сургалт мэдээлэл, өгөөд

явж байна. энэ үйлчилгээнд мөн тодорхой зардал гарах тохиолдол байдаг үүнийг өмгөөлөгч өөрийн халааснаасаа гаргаад ажлаа хийгээд явж байна. Нэгэнт хуульд заасан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх ажил тул тодорхой төлөвлөгөөтэй, төсөвтэй байх шаардлагатай гэж ойлгож байна.

Улсын өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас

Дээр дурдсан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллахад Хууль зүйн туслалцааны төв хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлэхдээ төрийн бусад байгууллагын хуульд заасан нийтлэг чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах, түүнчлэн энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь санхүүгийн дэмжлэг шаардлагатай байгааг судалгаанд хамрагдсан улсын өмгөөлөгчид илэрхийлсэн байна.

## **2.2. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг нийтэд сурталчилж, таниулсан байдал**

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 11 дүгээр зүйлийн 11.1.10-т Туслалцааны төв нь хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг нийтэд сурталчлах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заажээ.

Хууль зүйн туслалцааны төв нь 2022 онд хууль тогтоомж, байгууллагын чиг үүргийг сурталчлах ажлыг зохион байгуулах үндсэн зорилтыг дэвшүүлсэн бөгөөд үүний зэрэгцээ байгууллагаа таниулан сурталчлах зорилгоор иргэдтэй мэдээлэл солилцох урсгалыг хурдасгах, хуульд заасан нээлттэй мэдээллийг ил болгож цахим хуудаст тогтмол байршуулах, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлан, холбогдох мэдээллийг ил тод болгох зэрэг ажлуудыг төлөвлөсөн байна.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай 2013 оны хуулийг сурталчлах хүрээнд видео шторк, дохионы хэлтэй мэдээ видео, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг агуулсан постерууд, инфографик байдлаар хийсэн видео контент зэргийг ТВ8, UBS, МҮОНРТ, Ийгл ТВ, Боловсрол суваг телевизүүдэд сурталчлах, хамтран ажиллах тухай албан бичгийн хамт хүргүүлж, тус хуулийн агуулгаар 8 постер бэлтгэн фэйсбүүк цахим хуудсаар олон нийтэд түгээжээ.

Түүнчлэн иргэд хууль зүйн туслалцаа авах хүсэлтийг И-Монголиа системээр дамжуулан ирүүлэх нөхцөл боломж бүрдсэн талаарх мэдээлэл бүхий хоёр постер, иргэдэд зориулсан зарим заавар зэргийг байгууллагын фэйсбүүк хуудсаар олон нийтэд хүргэсэн байна. Мөн Монголын Үндэсний олон нийтийн радио телевизээс бэлтгэн хүргэдэг “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлгийн 2022 оны 5 дугаар сарын эхний дугаарт оролцож, Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, хууль зүйн туслалцааг хэрхэн авах, улсын өмгөөлөгчийн ажлын нэг өдрийг харуулсан контентыг бэлтгэх ажлыг зохион байгуулжээ.

Харин Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 2022 оны шинэчилсэн найруулга батагдсаны дараа тус хуулийг олон нийтэд сурталчлах, таниулах зорилгоор нийт 5 брошур, танилцуулга, видео контент, шторк бэлтгэн тэдгээрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэд түгээж, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг 1800-1202 подкастад оролцох, “Тогтвортой хөгжлийн зорилго” нээлттэй өдөрлөгт оролцож иргэд, олон нийтэд Хууль зүйн туслалцааны тухай хууль, Төвийн үйл ажиллагааны талаар сурталчилж, үнэ төлбөргүй өмгөөллийн зөвлөгөө, мэдээлэл өгч, брошур тараах ажлуудыг гүйцэтгэжээ.

Тус байгууллагаас судалгааны багт хүргүүлсэн мэдээллийг дүгнэж үзэхэд ХЗТТ-өөс 2022 онд хууль зүйн туслалцаланы тухай хууль тогтоомж болон байгууллагаа сурталчлах

чиглэлээр Монголын үндэсний олон нийтийн ради болон телевиз, Монгол HD, Парламент, NTV, Eagle, 25 дугаар суваг, TV8 телевизүүд болон Өрөг цахим сайт зэрэг нийт 16 телевизийн болон радио нэвтрүүлэг, подкастад оролцсон, цөөнгүй тооны постер хийлгэж тэдгээрийг ашиглан уралдаанд оролцсон, эдгээр постерууд болон холбогдох танилцуулга, мэдээллүүдийг төвийн албан ёсны цахим сайт, фейсбүүк пэйжээр олон нийтэд түгээх, бусад байгууллагуудтай хамтран нийслэлийн болон орон нутгийн Засаг даргын Тамгын газрын хуулийн хэлтсийн дарга нар, иргэд, олон нийтэд биечлэн мэдээлэл хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Иргэн хууль зүйн туслалцаа хүссэн өргөдлийг цахимаар ирүүлж шийдвэрлүүлэх боломж бүрдсэн бөгөөд хууль зүйн туслалцааны мэдээллийн нэгдсэн сан дахь И-Монголиа системээр дамжуулан хууль зүйн туслалцаа хүссэн өргөдлийг 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хүлээн авч байгаа ба 2022 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар нийт 71 хууль зүйн туслалцаа хүссэн өргөдлийг хүлээн авсан нь сайшаалтай байна.

Эдгээрээс гадна нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг ил болгож цахим хуудаст тогтмол байршуулах, хуульд заасан холбогдох мэдээллийг ил болгож, цахим хуудаст байршуулах, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа агентлаг, байгууллагууд болон Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын Хуульчдын холбооны цахим сайт, телевиз, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн байгууллагуудтай хамтран нийтэд хүргэжээ.

Харин тус байгууллагын үйл ажиллагааны талаар үйлчлүүлэгчдээс авсан судалгаанд оролцогчдоос танил тал, хүмүүсийн ярианаас ХЗТТ-ийн болон улсын өмгөөлөгчдийн үйлчилгээний талаар мэдээллийн олж авсан иргэд хамгийн олон (44.6 хувь) байгаа анхаарал татаж байв.

*График 29. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчдийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийг олж авсан эх сурвалж*



Өөрөөр хэлбэл өмнө нь ХЗТТ-өөс үйлчилгээ авсан иргэд тус байгууллагын үйлчилгээг бусад шаардлагатай иргэдэд хүргэж буй мэдээллийн эх үүсвэр болж байна. Мөн үйлчилгээ авсан иргэд улсын өмгөөлөгчдийн үйлчилгээг бусдад санал болгож буй буюу үйлчилгээнд сэтгэл хангалуун үлдсэнийг харуулах үзүүлэлт гэж үзэж болохоор байна.

Хамтын ажиллагаа бүхий байгууллагаас мэдээлэл авч буй байдлыг харвал судалгаанд хамрагдсан иргэдийн 25 хувь буюу 4 үйлчлүүлэгч тутмын 1 нь анх цагдаагийн байгууллагаас ХЗТГ-ийн болон улсын өмгөөлөгчийн үйлчилгээний талаар мэдээлэл авсан байна. Прокуророос мэдээлэл авсан байдал хамгийн бага буюу 1.4 хувь нь прокуророос мэдээллийг олж авсан байна.

Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгч иргэдийн 5.4 хувь нь ХЗТГ-ийн цахим хуудсанд зочилж байсан туршлагатай байв. Харин цахим хуудсанд зочилсноор хэрэгтэй мэдээллээ олж авч чадсан эсэхийг тодруулахад 29.4 хувь нь тийм гэж хариулсан байна. Цахим хуудсыг мэддэггүй байдал 94 гаруй хувь, цахим хуудаснаас хэрэгтэй мэдээллээ олж авах байдал 30 орчим хувь байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Цаашид цахим хуудсыг сурталчлан таниулах, цахим хуудасны мэдээллийг иргэн, үйлчлүүлэгчдэд энгийн, ойлгомжтой хэлбэрээр байршуулах, түгээмэл асуулт, хариултын буланг хөгжүүлэх замаар цахим хуудаст зочилсон үйлчлүүлэгч бүр эрж, хайсан мэдээллээ олж авах боломжийг цаашид бүрдүүлэх шаардлагатай байна.

График 30. ХЗТГ-ийн цахим хуудсанд зочилж байсан эсэх






График 31. Хэрэв "Тийм" бол хэрэгтэй мэдээллээ авч чадсан уу?




Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар хамтран ажиллагч байгууллагууд мэдээлэл авсан эсэхийг тодруулж үзэхэд судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллийн 51.5 хувь буюу 2 оролцогч тутмын 1 нь Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдээлэл авсан байна. Байгууллагаар ангилан авч үзвэл шүүхийн байгууллагаас оролцогчдын 63.2 хувь нь, цагдаагийн байгууллагаас оролцогчдын 57.1 хувь нь, ШШГЕГ-аас оролцогчдын 53.8 хувь нь мэдээлэл авсан байна. Харин прокурорын байгууллагаас оролцогчдын 35.7 хувь буюу бусад байгууллагатай харьцуулахад мэдээлэл авсан хувь бага байна.

График 32. Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн талаарх байр суурь



Харин хамтран ажиллагч байгууллагуудын төлөөллөөс 53.3 хувь нь хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажил сайн, дунд гэж үнэлснийг энэхүү судалгааны 21 дэх графикаас үзэж болохоор байна. Үүний зэрэгцээ хамтын ажиллагаа бүхий бусад байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн хувьд 27.4 хувь нь ХЗТТ-ийн талаар мэдлэг, мэдээлэл сайтай байгаа бол дийлэнх буюу 68.4 хувь нь мэдээлэл муу, 4.2 хувь нь буруу ташаа ойлголттой байгааг доорх графикаас харж болохоор байна.

График 33. Тухайн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн ХЗТТ-ийн талаарх мэдлэг, мэдээллийг үнэлж буй байдал



Эдгээрийг дүгнэж үзвэл ХЗТТ нь Хууль зүйн туслалцааны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэд, олон нийт, байгууллагуудад хууль тогтоомж, байгууллагын чиг үүргийг сурталчлахад чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч эцсийн дүндээ тухайн байгууллагаар үйлчлүүлсэн иргэд бие биеэсээ буюу бусад иргэдээс мэдээлэл авч байсан нь хамгийн өндөр тоотой, хамтран ажиллагч байгууллагын албан хаагчдын тэн хагас нь Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдлэггүй, хамтын ажиллагаа бүхий байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн дийлэнх нь ХЗТТ-ийн талаар мэдээлэлгүй эсвэл буруу ташаа мэдээлэлтэй байгаа нь ажиглагдлаа.

Иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэхдээ иргэдийг орлогоор нь ангилах, байгууллагуудыг чиг үүргээр нь ангилах, шаардлагатай бол тодорхой албан тушаалтнуудыг зорилтот бүлэгт ангилах зэргээр мэдээлэл, сурталчилгааны ажлыг тэдэнд шууд чиглүүлэн хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байж болохоор байна. Мөн өмнөх жилийн хэрэглэгчийн үнэлгээний судалгааны зөвлөмжид ч мөн адил амьжиргааны төвшнөөс доогуур орлоготой иргэдэд чиглэсэн мэдээлэл хүргүүлэх арга замыг боловсруулах, баг, хорооны нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллах зэрэг тодорхой арга замуудыг санал болгосон байсныг дурдах нь зүйтэй.

Зохимжтой бол улсын өмгөөлөгч бүр үйлчлүүлэгч иргэдээс ХЗТТ-ийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэрхэн авах хүсэлтэй байгаа талаар богино асуулгыг асууж бөглөн тодорхой хугацааны дараа асуулгын судалгааг нэгтгэн дүгнэх байдлаар тухайн орон нутаг бүрийн онцлогийг тодорхойлж, судалгааны үр дүнд үндэслэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй юм. ХЗТТ-ийн мэдээлэл, сурталчилгааны ажлын хүртээмж, үр дүнг үнэлэх аливаа шалгуур үзүүлэлт үндсэндээ байхгүй, мэдээлэл авсан иргэд, байгууллагуудтай эргэх холбоо муутай байгаа нь дараагийн мэдээллийг түгээх зөв арга замыг сонгоход саад болж байна гэж үзэх үндэслэлтэй байгааг анхаарах нь зүйтэй юм.

### **2.3. Хууль зүйн туслалцааны төвийн гадаад, дотоод хамтын ажиллагаа, санхүүжилт, бусад байгууллагын оролцоо**

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 11 дүгээр зүйлийн 11.1.9-т ХЗТТ нь чиг үүргийн хүрээнд гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах, олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр, тус зүйлийн 11.1.4-т улсын өмгөөлөгчийн хуульчийн үргэлжилсэн болон мэргэшүүлэх сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, 11.1.5-т салбар байгуулагдаагүй нутаг дэвсгэрт хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах, 11.1.11-т эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах, бусад байгууллагатай хамтран ажиллах гэж гадаад дотоод хамтын ажиллагааг хэрэгжүүлэх хүрээг нь тодорхой зааж өгсөн байна.

Хууль зүйн туслалцааны төв нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх гэсэн үндсэн зорилтуудыг тусгаснаас гадна байгууллагын мэдээллийн нэгдсэн санд суурилсан программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх, улсын өмгөөлөгчийг хуульчийн багц цаг цагийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах, албан хаагчдын стрессийн түвшний судалгааг гаргах, зөвлөмжийн дагуу арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх гэсэн ажлуудыг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Түүнчлэн энэхүү тайлангийн дээрх 2.2 дугаар хэсэгт хууль тогтоомж, байгууллагын чиг үүргийг сурталчлах ажлыг зохион байгуулахдаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай нягт хамтран ажилласан болохыг энд дурдах нь зүйтэй гэж үзэж байна.

#### **Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр**

ХЗТТ нь 2022 онд гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран улсын өмгөөлөгчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 1-2 удаагийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байсан байна. Гэвч тухайн жилд энэхүү төлөвлөгөөгөө давуулан биелүүлж олон улсын хэд хэдэн байгууллагатай техник, эдийн засгийн өргөн хүрээнд хамтран ажилласан байна.

ХБНГУ-ын Ханнс Зайделийн сангаас ХЗТТ-ийн төлөөлөгчид Увс, Баян-Өлгий

аймагт ажиллах албан томилолтын зардлыг болон улсын өмгөөлөгчдийн хуульчийн багц цаг тооцох 2 кредитийн сургалтыг зохион байгуулахад зардлыг тус тус бүрэн санхүүжүүлсэн бөгөөд 2023 онд Хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад ХЗТТ-тэй хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж амжилттай хамтран ажилласан байна.

Мөн “Нээлттэй нийгэм форум” ТББ, ХЗТТ-ийн хамтарсан ажлын хэсэг байгуулан төвийн нийт улсын өмгөөлөгчдөд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо” сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд цаашид ч хамтран ажиллахаар тохиролцсон байна.

Эдгээрээс гадна БНХАУ-ын Хууль зүйн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төв, Олон улсын эрх зүйн сан /ILF/, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага /IDLO/, Канад улсын Онтарио мужийн Хууль зүйн туслалцааны төв, Бүгд Найрамдах Польш Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд зэрэг олон улсын болон гадаадын дипломат албан тушаалтнуудтай холбогдож цаашид хүний эрхийг хангах, хууль зүйн туслалцааны үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тохиоролцоо хийсэн байна.

### **Дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр**

Дотоод дахь хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр ХЗТТ нь 2022 онд юуны өмнө Сихихутуг Их Сургууль, Оюуны инноваци ТББ, Хүмүүнлэгийн их сургуулийн харьяа Билиг дээд сургууль, болон АШУҮИС-ийн багш, сэтгэл засалч Р.Энхтүвшин нартай хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан бөгөөд Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын Хуульчдын холбоо, Монголын Нотариатчдын танхимтай Санамж бичиг байгуулахаар тохиролцон Санамж бичгийн төслийг солилцох хүртэл арга хэмжээ авч амжилттай ажилласан байна.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 24 дүгээр зүйлд Монголын Хуульчдын холбоо нь улсын өмгөөлөгчийг хуульчийн үргэлжилсэн болон мэргэшүүлэх сургалт зохион байгуулахад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлж, хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах бөгөөд улсын өмгөөлөгчийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн бол шийдвэрийг ХЗТТ-д хүргүүлэх байдлаар хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд хамтран ажиллана гэж заажээ. ХЗТТ нь дотоод хамтын ажиллагааны хүрээнд нийт улсын өмгөөлөгчдийг хуульчийн багц цагийг хангах 4 кредитийн сургалтад бүрэн хамруулсан талаар мэдээлэл байгаа боловч Хуульчдын холбоо нь ХЗТТ-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажилласан эсвэл улсын өмгөөлөгчийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн талаар мэдэгдсэн тохиолдол энэхүү судалгааны явцад илрээгүй байна.

Харин Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлд Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах, тус холбооноос улсын өмгөөлөгчид үзүүлэх хөнгөлөлт, урамшууллын тогтолцоог бий болгох, эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг ХЗТТ-ийн захирал, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч хамтран батлах бөгөөд улсын өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон, дуусгавар болгосон, түдгэлзүүлсэн бол шийдвэрийг ХЗТТ-д мэдэгдэх байдлаар хамтран ажиллана гэж заасан байна. Эдгээрээс “Хувийн өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны журам”-ы төслийг ХЗТТ-өөс боловсруулж Монголын Өмгөөлөгчдийн



холбоонд хүргүүлсэн байгаа бөгөөд өмгөөлөгчид үзүүлэх хөнгөлөлт, урамшууллын тогтолцоог бий болгох, улсын өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон, дуусгавар болгосон, түдгэлзүүлсэн талаар мэдээлэл хүргүүлж хамтран ажилласан тохиолдол судалгааны явцад илрээгүй байна.

АШУҮИС-ын эмгэг судлал, шүүх эмнэлгийн тэнхимийн багш, мэргэжлийн сэтгэл зүйч эмч нартай хамтран Төвийн нийт албан хаагчдад “Тэмт хэргийн хохирогч, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэдтэй харилцахад анхаарах зүйлс” сэдвээр захиалгат сургалт зохион байгуулсан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын өгсөн чиглэлийн дагуу нийт албан хаагчдад шахмал түлш түлэх арга ажиллагаа болон угаартахаас уртлчилан сэргийлэх тухай холбогдох мэдээлэл, танилцуулгыг цахимаар, дотоод сүлжээгээр хүргэж, олон нийтэд төвийн [www.lac.gov.mn](http://www.lac.gov.mn) цахим хуудсаар мэдээлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн зэргийг дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр хийсэн ажил гэж үзэж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа нь үндсэндээ төрийн, төрийн бус, олон улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаатай нягт холбоотой бөгөөд гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх нь байгууллагын нэн тэргүүнд ач холбогдол өгөх чухал ажил болох нь тодорхой байна. Энэ чиглэлээр ХЗТТ төрөл бүрийн үйл ажиллагааг санаачлан ялангуяа цахим хөгжил буюу байгууллагын үйл ажиллагаагаа цахимжуулах болон албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх хүрээнд хамтын ажиллагааг илүү сайн ашигласан нь ажиглагдаж байна.

Тус төв нь гадаад, дотоодын хэд хэдэн байгууллагатай хамтын ажиллагааны Санамж бичиг батлахаар тохиролцсон, заримынх нь төслийг боловсруулж дууссан байгаа нь сайшаалтай юм. Хамтын ажиллагаагаа цаашид өргөжүүлэн хөгжүүлэхдээ ХЗТТ нь зорилтот бүлгүүдэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг давхцалгүй, үр дүнтэй байхаар төлөвлөн хэрэгжүүлэх, байгууллагын албан хаагчдад чиглэсэн ажлаас илүү гадагш буюу иргэд, хамтран ажиллагч байгууллагуудад чиглэсэн ажлуудад илүү ач холбогдол өгөх, боломжтой бол академик судалгаа, шинжилгээний үйл ажиллагаанд хамтын ажиллагааг чиглүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

## **ГУРАВ. УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

### **3.1. Улсын өмгөөлөгчийн ажиллах орчин нөхцөл**

Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 16 дугаар зүйлийн 16.1-т Улсын өмгөөлөгч нь хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэх үндсэн үүрэгтэй, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл баталгаагаар хангагдан ажиллаж байгаа, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй, хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа албан хаагч байна гэж хуульчилсан байна.

Улсын өмгөөлөгч нь төрийн албан хаагчид хамаарах бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно гэсэн суурь хэм хэмжээний хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 16 дугаар зүйлд заасан Улсын өмгөөлөгчийн ажиллах нөхцөл, баталгааг эдэлнэ.

Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-т Төсвийн шууд захирагч тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн

төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ гэж заасны дагуу Хууль зүйн туслалцааны төвийн 2022 онд боловсруулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, улсын өмгөөлөгч, үйлчлүүлэгч, хамтын ажиллагаатай байгууллагын төлөөллөөс асуулга болон ярилцлагын аргаар судалгаа авч улсын өмгөөлөгчийн ажиллах нөхцөл, баталгаанд зохих үнэлгээ хийсэн болно.

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хууль зүйн туслалцааны төвийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тогтолцоог бэхжүүлэх, үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулах зорилтын хүрээнд Орон нутаг дахь салбарын ажлын байрны асуудлыг шийдвэрлүүлэх, ажлын байрны нөхцөлийг сайжруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж гүйцэтгэл нь 100 хувьтай хэрэгжсэн гэжээ. Үүнд:

- Говьсүмбэр, Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газраас улсын өмгөөлөгчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэсэн ажлын байраар хангасан;
- Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь салбарыг нэг цонхны үйлчилгээний газраас шилжүүлэн ажлын байрны нөхцөлийг сайжруулан Засаг даргын Тамгын газарт ажлын байраар хангаж, цаашид Засаг даргын Тамгын газраас улсын өмгөөлөгчийн ажлын онцлогт тохирсон үйлчлүүлэгчтэй ганцаарчлан уулзах уулзалтын өрөө /хувь хүний нууцыг хамгаалах зорилгоор/ хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллахаар зөвшилцөлд хүрсэн байна.
- Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн хангах хүрээнд 21 аймаг, 8 дүүрэг, 2 сумын Засаг дарга нарт 2022 оны 11 дүгээр сард хамтран ажиллах, дэмжлэг хүсэх тухай албан бичиг хүргүүлж, тухайн албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын Тамгын газрын хуулийн хэлтэстэй холбогдож, салбаруудын ажлын байрыг сайжруулахтай холбоотой санал хүсэлтийг хүргүүлсэн тухай болон авах арга хэмжээний талаар танилцуулж, тус ажлын хүрээнд :
  1. 11 аймаг, 1 дүүргийн Засаг даргын Тамгын газар дэмжиж хамтран ажиллах хариу ирүүлсэн (Архангай аймаг, Баян-Өлгий аймаг, Баянхонгор аймаг, Булган аймаг, Говь-Алтай аймаг, Дорнод аймаг, Өвөрхангай аймаг, Хөвсгөл аймаг, Хэнтий аймаг, Увс аймаг, Сүхбаатар аймаг, Сонгинохайрхан дүүрэг);
  2. 2 аймаг, 2 дүүргийн Засаг даргын Тамгын газар дэмжих боломжгүй гэсэн хариу ирүүлсэн (Сэлэнгэ аймаг, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Налайх дүүрэг, Баянзүрх дүүрэг)
  3. 10 аймаг, 4 дүүргийн Засаг даргын Тамгын газар тодорхой хариу ирүүлээгүй (Төв аймаг, Дорноговь аймаг, Дорноговь аймгийн Замын үүд сум, Дархан-Уул аймаг, Завхан аймаг, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Ховд аймаг, Орхон аймаг, Говьсүмбэр аймаг, Дундговь аймаг, Хан-уул дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Багануур дүүрэг, Баянгол дүүрэг) гэж тус тус илэрхийлсэн байна.

#### Шигтгээ

Ажиллах орчин нөхцөл тааруу, хүрэлцээгүй байдаг. Тухайлбал дөрвөн дүүргийн 12 улсын өмгөөлөгч, гурван туслахын хамт нэг жижиг өрөөнд сууж ажлаа хийдэг, ширээ сандал хүрэлцдэггүй. Мөн үйлчлүүлэгчтэй уулзах уулзалтын өрөө жижиг, хүйтэн, шаардлага хангадаггүй. Уулзалтыг өрөөг даруй тохижуулах шаардлагатай байна.

Улсын өмгөөлөгчийн өрөө тухгүй, хүртээмжгүй талаар үйлчлүүлэгчид болон хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөлөл онцолж байсан. Мөн улсын өмгөөлөгчдийн зүгээс үйлчлүүлэгчтэй уулзах уулзалтын өрөө жижиг, хүйтэн, шаардлага хангадаггүй тул тохижилт хийх шаардлагатай болохыг ярилцлагын судалгааны үед онцолж байв.

График 34. Улсын өмгөөлөгчөөр ажиллахад тулгарч буй гол бэрхшээл




Судалгаанд хамрагдсан улсын өмгөөлөгчийн 45 хувь нь улсын өмгөөлөгчөөр ажиллахад материаллаг орчин нөхцөл тулгарч буй гол бэрхшээл гэж үзэж байна. Түүнчлэн нийслэлийн улсын өмгөөлөгчийн 64.3 хувь нь ажиллах орчин нөхцөл тулгарч буй гол бэрхшээл гэж үзсэн нь орон нутгийн улсын өмгөөлөгчдөөс 29.7 хувиар илүү өндөр байна.

**Шигтгээ**

Улсын өмгөөлөгчдийн хувьд ажлаа хийх компьютер, техник, тоног төхөөрөмж байхгүй, бичиг хэргийн зардал өгдөггүй учраас өөрсдөө хэргийн материалын зургийг утсаараа авах, хорих анги руу явж үйлчлүүлэгчтэйгээ уулзахад байгууллагаас унаа гаргаж өгдөг боловч тэр нь хэрэлцдэггүй өөрийн унаагаар явах, хоол унааны зардал өөрөөсөө гаргах байдлаар л ажлаа хийж байна.

График 35. Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлд заасан Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй байдлын үнэлгээ



Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлд Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулж өгсөн нь шинэ хуулийн нэг ололт, сайжруулсан зохицуулалт билээ. Хэдий тийм боловч хууль хэрэгжээд 2 сарын хугацаа өнгөрсний дараа тус заалт хэрэгжилт хангалтгүй байгаа нь улсын өмгөөлөгчдийн дээрх үнэлгээнээс харагдаж байна. Тухайлбал салбарыг стандартын шаардлага хангасан ажлын байр, техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр хангах заалт муу хэрэгждэг гэж 39 хувь нь, хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тухайн нутаг дэвсгэрт ажиллахаар томилогдсон улсын өмгөөлөгчийг орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх заалт муу хэрэгждэг гэж 75 хувь нь, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын салбарын өмгөөлөгч, ажилтныг орон сууц, тээврийн хэрэгслээр хангах, улсын өмгөөлөгч, түүний гэр бүлийн гишүүнд дэмжлэг үзүүлэх заалт муу хэрэгждэг гэж 82.9 хувь нь хариулсан байна. Иймд дээрх зохицуулалтыг хэрэгжилтийг хангах замаар улсын


өмгөөлөгчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад анхаарах нь зүйтэй байна.

### Шигтгээ

Хууль зүйн орчин, үйлчилгээ үзүүлэх хүрээ тэлсэнтэй холбогдуулан ажлын ачаалал ихсэх хандлага ажиглагдаж байна. Ер нь ажиллах орчин болон байршил их чухал манай туслалцааны төвийн байршил бол бусад хамтран ажилладаг байгууллагуудтай ойр байдаг хэдий ч ажиллах орчин өвөлдөө хүйтэн, дулааны улиралд чийгшил ихтэй. 2 өмгөөлөгч суухад өрөө тасалгааны хүртээмж дөнгөж хүрэлцэх төдий байдаг. Үйлчлүүлэгчтэй уулзах өрөө тасалгаа байхгүй. Бичиг хэргийн зардал хүрэлцдэггүй, унаа, хоолны мөнгө байхгүй гэх мэт ажиллах орчны наад захын хэрэгцээ хангагдахгүй байсаар ирсэн. Хуулийн шинэчилсэн найруулгад эдгээр асуудлыг шийдвэрлэхээр тусгасан ч нийтлэг байдлаар санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэж өгдөггүйн улмаас хууль хэрэгждэггүй байдал үргэлжилсээр байгааг шийдвэр гаргах, төсөв батлах түвшнийхэн анхааралдаа аваасай гэж хүсэж байна.

Улсын өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас

Зураг 1. Хууль зүйн туслалцааны төвийн Дархан-Уул аймаг дахь салбар (Буян захад байрлах)



Зураг 2. Хууль зүйн туслалцааны төвийн Сэлэнгэ аймаг дахь салбар (Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын засаг даргын тамгын газарт байрлах)



### 3.2. Улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал ба тохирсон цалин хөлс

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно гэж, мөн зүйлийн 2.4 дэх хэсэгт Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ гэж төрийн албан хаагчид цалин хөлс олгох хэм хэмжээг тусгасан байна.

Улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал, тохирсон цалин хөлсний талаар холбогдох хууль тогтоомжийг судлан, Хууль зүйн туслалцааны төвийн 2022 оны гүйцэтгэлийн тайлан, улсын өмгөөлөгчөөс асуулга, ганцаарчилсан ярилцлагын судалгаа хийн үнэлгээ хийсэн.

Төвийн 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд Улсын өмгөөлөгчдийн цалин хөлс, урамшууллын тогтолцоо, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр дараахь ажлыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган 100 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн гэжээ. Тухайлбал, улсын өмгөөлөгчдийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. Төвийн албан хаагчийн ажлын үр дүнг шалгуурын дагуу үнэлж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдсанаар улсын өмгөөлөгч дараах нийгмийн баталгаагаар хангагдах эрх зүйн орчин бүрдсэн. Үүнд:


- өмгөөлөгчийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангагдах;
- жил бүр төрийн зардлаар эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдах;
- хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд мөнгөн урамшууллыг олгох;
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасан гишүүний татвар, өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын хураамж, хуульчийн үргэлжилсэн сургалтын төлбөрөөс улсын өмгөөлөгчөөр ажиллах хугацаанд чөлөөлөгдөх г.м

Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-д зааснаар улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн албан тушаалын цалингийн хэмжээг прокурорын албан тушаалын цалинтай дүйцүүлсэн итгэлцүүрээр цалинжих эрх зүйн орчин бүрдүүлсэн талаар дараах эрх зүйн актыг боловсруулж, батлуулсан байна.

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Хууль зүйн туслалцааны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөө”-ний хүрээнд “Улсын өмгөөлөгчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн ба Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр тус журмыг баталсан.
2. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хамтарсан А/104, А/83, 88 тушаалаар “Улсын өмгөөлөгч болон улсын өмгөөлөгчийн туслахад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийг батлан тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд 2022 оны 6 дугаар сард улсын өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн туслахын ур чадварыг 2022 оны эхний хагас жилийн байдлаар үнэлж, нэмэгдлийг 2022 оны 7 дугаар сараас эхлэн олгосон.

Мөн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2022 оны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулж, 4 албан хаагч /ар гэрийн гачигдал, хүндээр өвдсөн эмчилгээний зардал/-д нэг удаагийн буцалтгүй тусламж, нийт 13 албан хаагч төрийн алба хаасан удаан хугацааны нэмэгдэл, ердийн галлагаатай сууцанд амьдардаг 9 албан хаагчдад түлш худалдан авахад нь зориулан нөхөх төлбөрийг тус тус олгосон байна.

График 36. Улсын өмгөөлөгч өөрийн ажлын ачааллаа үнэлсэн байдал



Улсын өмгөөлөгчдийн 53.7 хувь нь ажлын ачаалал ихтэй гэж хариулсан бол 46.3 хувь нь хэвийн ачаалалтай гэж үзсэн байна. Байршлаар авч үзвэл нийслэлд ажиллаж буй улсын өмгөөлөгчдийн 71.4 хувь нь ажлын ачаалал ихтэй гэж үзэж байгаа болон орон нутагт ажиллаж буй улсын өмгөөлөгчдийн хувьд 44.4 хувь нь ачаалалтай ажилладаг гэж үзжээ.


#### Шигтгээ

Улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал нийслэлийн хэмжээнд их, нэг өмгөөлөгч жилд багадаа 50-60 хэрэгт өмгөөлөгчөөр оролцдог. Хөдөө орон нутгийн хувьд ачаалал харьцангуй гайгүй байдаг. Ийм ураас ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд анхаарч, нийслэлд орон тоо нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай. Мөн улсын өмгөөлөгч оролцох хэрэг, маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотой өмгөөлөгчийг салбар эрх зүйн чиглэлээр мэргэшүүлэх, орон тоо нэмэх шаардлагатай гэж байна.

Улсын өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас

Тоон болон чанарын судалгааны үр дүнгээс харвал улсын өмгөөлөгчдийн ажиллаж буй байршлаас хамаарсан ачааллын ялгаа ажиглагдаж байгаа бөгөөд ажлын ачаалалд үндэслэн орон тоог нэмэх, ачааллыг тэнцвэржүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

График 37. Долоо хоногт ажлын шаардлагаар ажил дээрээ оройтох болон илүү цагаар ажилладаг давтамж



Нийслэлд ажиллаж буй улсын өмгөөлөгчдийн 42.9 хувь нь амралтын өдрүүдээр ч ажиллах үе гардаг гэсэн болон орон нутагт ажиллаж буй улсын өмгөөлөгчдийн хувьд 37

хувьтай байна. Мөн долоо хоногт ажлын шаардлагаар 2-3 удаа оройтох болон илүү цагаар ажиллах явдал түгээмэл буюу орон нутгийн улсын өмгөөлөгчдийн 51.9 хувь, нийслэлийн өмгөөлөгчдийн 42.9 хувьд ажиглагдаж байна. Цаашид улсын өмгөөлөгчдийн ажлын цаг ашиглалт болон ажлын ачааллын судалгааг гүйцэтгэсний үндсэн дээр орон тоог зохист түвшинд хүргэх замаар ажлын ачааллын тэнцвэржүүлэх нь зүйтэй байна.

График 38. Өөрийн хийж байгаа ажилдаа тохирохуйц цалин хөлс авдаг эсэх





График 39. Хүсэж буй цалингийн хэмжээ



Улсын өмгөөлөгчдийн 92.7 хувь нь өөрийн хийж байгаа ажилдаа тохирохуйц цалин хөлс авдаггүй гэжээ. Байршлаар авч үзвэл нийслэлд ажиллаж буй улсын өмгөөлөгчид 100 хувь өөрийн хийж буй ажилдаа тохирохуйц цалин хөлс авдаггүй гэж үзсэн байна. Харин хүсэж буй цалингийн хэмжээний хувьд 2 сая төгрөгөөс 3 сая төгрөгийн хооронд цалин авах хүсэлтэй гэж 92.3 хувь нь хариулжээ. Орон нутгийн улсын өмгөөлөгчдийн 55.6 хувь нь 2 сая төгрөгийн цалин авах нь зохистой гэж үзэж буй бол нийслэлийн улсын өмгөөлөгчдийн 50 хувь нь 3 сая төгрөгийн цалин авах хүсэлтэй, тохиромжтой гэж үзэж байна.


### 3.3. Улсын өмгөөлөгчийн мэргэшүүлэх сургалт

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.4-т хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, тодорхой багц цаг хангах гэж хуульчилж, МХХ-ны Зөвлөлийн 2014 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам”-ын 6.1 дүгээр зүйлийн 1-т Хуульч жил бүр 4-өөс доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байх бөгөөд 1-ээс багц цаг нь мэргэжлийн суурь сургалт, 3 багц цаг нь мэргэшүүлэх чиглэлийн сургалт байна гэж, Өмгөөллийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т Өмгөөлөгчийн шалгалт болон үргэлжилсэн сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий Мэргэшлийн хороо ... ажиллах гэж хуульчилж, МӨХ-ны Удирдах зөвлөлийн 2021 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Мэргэшлийн хорооны ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-т Мэргэшлийн хороо нь өмгөөлөгчийн шалгалт болон үргэлжилсэн сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий Өмгөөллийн холбооны бүтцийн байгууллага... мөн зүйлийн 3.3-т Өмгөөлөгчийн үргэлжилсэн сургалтын зорилго нь өмгөөлөгчийн мэргэшлийн мэдлэг, ур чадвар, мэргэшсэн байдлыг шинжлэх ухааны орчин үеийн онол, үзэл баримтлал, эрх зүйн шинэтгэлийн хандлага, практик нийцүүлэн дээшлүүлж, мэргэжлийн ёс зүйг чанд мөрдөж, шударга хараат бусаар тууштай ажиллах чадварыг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ гэж заажээ. Хууль зүйн туслалцааны тухай хууль(шинэчилсэн найруулга)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх үйл ажиллагаанд хуульчийн мэргэжлийн болон өмгөөллийн үйл ажиллагааны зарчмаас гадна мэргэшсэн, тогтвортой байх гэсэн тусгай зарчмыг хуульчилсан нь улсын өмгөөлөгч нь нийгмийн эрэлт хэрэгцээнд үндэслэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд эрх зүйн салбараар болон сэтгэл зүйн суурь мэдлэг ойлголттой болох хэрэгцээ шаардлага үүсэж буйг тэмдэглэж байна. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн




шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор үйлчлүүлэгчийн хүрээ өргөсөн улсын өмгөөлөгчдөд салбар эрх зүйгээр мэргэшэх хэрэгцээ шаардлага үүссэн эсэх талаар болон цаашид зохион байгуулах хуульчийн үргэлжилсэн сургалтад өмгөөлөгчийн мэргэшин ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалтыг ямар хөтөлбөр боловсруулах талаар хийсэн судалгааны дүнг танилцуулж байна.

График 40. Улсын өмгөөлөгчийн мэргэшсэн салбар эрх зүй




Нийт судалгаанд хамрагдсан улсын өмгөөлөгчдийн 62.5 хувь нь нийтийн эрх зүйн салбараар, 37.5 хувь нь хувийн эрх зүйн салбараар мэргэшсэн гэж хариулжээ. Энэ нь Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн үйлчлэлээр иргэд, үйлчлүүлэгчид үзүүлж ирсэн үйлчилгээний төрлөөс хамааралтайгаар мэргэшин ажиллаж ирснийг илтгэж байна.

График 41. Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг ханган ажиллахад бэлэн эсэх




Судалгаанд хамрагдсан нийт өмгөөлөгчдийн 85.4 хувь нь хуулийн хэрэгжилтийг хангахад бэлэн гэж хариулсан бол 14.6 хувь нь бэлэн бус буюу мэргэшүүлэх сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага буйгаа илэрхийлсэн байна.

График 42. Улсын өмгөөлөгчөөс иргэний болон захиргааны хэрэгт ажилласан эсэх (Хууль зүйн тусалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/ үйлчилсэн хугацаанаас хойш)



Судалгаанд хамрагдсан нийт өмгөөлөгчийн 20 хувь нь иргэний болон захиргааны хэрэг маргаанд өмгөөлөгчөөр ажилласан, 80 нь ажиллаагүй гэж хариулсан бол орон нутагт ажиллаж буй улсын өмгөөлөгчдийн 26.9 хувь нь иргэний болон захиргааны хэрэг маргаанд өмгөөлөгчөөр ажилласан, 73.1 хувь ажиллагаагүй хариулсан байна. Энэ нь нийслэл болон орон нутгийн иргэд, үйлчлүүлэгчийн тухайн хуулийн талаарх мэдээлэлтэй холбон тайлбарлах боломжгүй бөгөөд харин орон нутгийн иргэд улсын өмгөөлөгчөөс хууль зүйн зөвлөгөө авах явцдаа хуулийн үйлчлэлийн хүрээ өргөсөж, иргэний болон захиргааны хэрэг маргаанд өмгөөлөгч авах боломжтой талаар мэдээлэлтэй болсонтой холбон үзэж болох юм.


График 43. Эрх зүйн салбараар мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамрагдах хэрэгцээ, шаардлага байгаа эсэх



Судалгаанд оролцсон нийт өмгөөлөгчдийн 82.9 хувь нь эрх зүйн салбараар мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага маш их болон их гэж хариулжээ. Түүнчлэн нийслэлийн өмгөөлөгчдийн 92.9, орон нутгийн өмгөөлөгчдийн 77.7 хувь нь хамрагдах шаардлагатай байгаагаа илэрхийлсэн байна. Хууль зүйн тусалцааны төвөөс улсын өмгөөлөгчийн хуульчийн үргэлжилсэн болон мэргэшүүлэх сургалтыг МХХ, МӨХ болон холбогдох бусад байгууллагатай хамтран 2022 оны 5 сард хуульчийн үргэлжилсэн сургалтын 2 багц цаг тооцох сургалтыг “Эрүүгийн хуулийн 17.10 дугаар зүйл буюу өмчлөгчийн эрхийг зөрчих”, “Өвлөх харилцаа”, “Шүүхийн мэтгэлцээн дэх өмгөөлөгчийн оролцоо” сэдвээр, мөн оны 12 дугаар сард хуульчийн үргэлжилсэн сургалтын 2 багц цаг тооцох сургалтыг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн оролцоо” сэдвийн хүрээнд, мөн сэтгэл заслын эмч, АШУҮИС-ийн багш, сэтгэцийн эмгэг судлалын магистр, докторант Р.Энхтүвшин "Хамт олны эерэг харилцаа" сэдэвт, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс санаачилсан “Хүний эрхийн хамгаалагчдад өмгөөллийн тусалцаа үзүүлэх нь” өмгөөлөгчдийн багийг чадавхжуулах сургалтыг тус тус

зохион байгуулжээ.


График 44. Хууль зүйн туслалцааны төвөөс явуулдаг Улсын өмгөөлөгчийг чадавхжуулах сургалтын чанар, үр өгөөжийн үнэлгээ



Хууль зүйн туслалцааны төвөөс хуульд заасан болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан дээр дурдсан мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтын чанар, үр өгөөжийг нийт судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн 80.5 хувь нь маш сайн, сайн, 17.1 хувь нь дунд, 2.4 хувь нь муу гэж үнэлснээс дүгнэн үзвэл тухайн жилд зохион байгуулсан сургалтыг үр өгөөжтэй болжээ гэж дүгнэж болохоор байна.

Цаашид мэргэшүүлэх сургалтын эрэлт хэрэгцээнд тулгуурлан, хамтын ажиллагаа бүхий байгууллагад сургалтын хөтөлбөр хамтран боловсруулах болон захиалгаар хөтөлбөр боловсруулуулах, МХХ-ны Сургалтын хороогоор магадлан итгэмжлүүлэх зэрэг ажлыг хуулийн дагуу хамтын оролцооны зарчимд үндэслэн хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Энэ нь хуульчийн үргэлжилсэн сургалтаар тооцуулах 3 багц цаг нь мэргэшүүлэх чиглэлийн сургалт байна гэж МХХ-ны Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журамд заасныг өөрийн байгууллагын хуульд заасан чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогт тохируулах боломжтойг илтгэж байгаа хэрэг юм.

График 45. Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл



Улсын өмгөөлөгчдийн 48.6 хувь нь улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааны талаарх иргэд, олон нийтийн мэдлэг хомс байдал үйл ажиллагаанд тулгарч буй гол бэрхшээл гэж үзжээ. Түүнчлэн 17.1 хувь нь улсын өмгөөлөгчийг мэргэшүүлэх, чадавхжуулах байдал

дутмаг явдал мөн тулгамдсан гэж үзжээ. Байршлаар авч үзвэл орон нутгийн улсын өмгөөлөгчдийн 20.8 хувь буюу 5 улсын өмгөөлөгч тутмын 1 нь улсын өмгөөлөгчийг мэргэшүүлэх, чадавхжуулах байдал дутмаг, 54.2 хувь нь буюу 2 улсын өмгөөлөгч тутмын 1 нь улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтийн мэдлэг хомс байдлыг тулгарч буй бэрхшээл гэж үзсэн. Иймд улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, улсын өмгөөлөгчийг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг чанаржуулах зэргээр тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулахыг зөвлөж байна.

## ДУГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын иргэн нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах ... эрхтэй” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүрэгтэй” гэж, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” гэж заасны дагуу Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 2014 онд батлан төлбөрийн чадваргүй яллагдагчид төрөөс үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг Хууль зүйн туслалцааны төв нь улсын өмгөөлөгч гэсэн статустай өмгөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2022 онд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаас хойш ч тус байгууллага хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Шинэчлэн батлагдсан Хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын өмгөөлөгчийн чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах нөхцөлийг сайжруулах, улсын өмгөөлөгчийн цалин хөлс, урамшуулал, техник хэрэгслийг нэмэгдүүлэх шаардлагатай. Ингэхдээ улсын өмгөөлөгчийн ажлын ачааллын судалгаа хийж, түүнд тохирсон цалин болон захиргааны зардлын тооцоог гаргах, өөрөөр хэлбэл тодорхой аргачлалын дагуу шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан судалгаанд тулгуурлан төсөв нэмэгдүүлэх замаар, ажлын байранд шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлэх нь зүйтэй.

Хамтын ажиллагаа бүхий байгууллагууд Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар болон улсын өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлэх хүрээ, чиг үүргийн талаар хангалттай мэдээлэлгүй гэж хариулах нь нийтлэг боловч улсын өмгөөлөгчийн ажлын ачааллыг хэвийн эсхүл бага гэж үзэж байна. Энэхүү дутуу, буруу ойлголт, мэдээлэл авч байгаа явдлыг залруулах хүрээнд Хууль зүйн туслалцааны тухай хууль болон ХЗТГ-ийн ажлын алба, улсын өмгөөлөгчийн чиг үүргийн талаарх мэдээллийг цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад хүргэх шаардлагатай байна. Ингэхдээ холбогдох байгууллагуудыг хамтран ажилладаг чиг үүргээр нь ангилах, шаардлагатай бол тодорхой албан тушаалтнуудыг зорилтот бүлэгт ангилах зэргээр мэдээлэл, сурталчилгааны ажлыг тэдэнд шууд чиглүүлэн хэрэгжүүлэх боломжтой.

Хамтын ажиллагаа бүхий байгууллагуудын зүгээс ХЗТГ-ийн үйл ажиллагаа, салбарын хаяг байршлын талаар мэдээлэлгүй байна. Энэ нь эргээд ХЗТГ-ийн үйлчилгээг иргэдэд, хурдан шуурхай хүргэхэд тулгарч буй гол бэрхшээлүүдийн нэг болж байна. Иймд гэмт хэрэгт сэжиглэгдсэн иргэний анхны үйлчилгээ авч буй цэг болох цагдаагийн хэлтэс, газруудад тодорхой мэдээллийг танилцуулж, байршуулах шаардлагатай байна.

ХЗТГ-ийн салбарын байршлыг хүн ам төвлөрсөн, нийтийн тээврийн олон чиглэл очих, эсхүл ЗДТГ, шүүх, цагдаагийн байранд байрлахын аль нь тохиромжтой болохыг судлан тогтоох хэрэгтэй бөгөөд салбарууд байршлын хувьд нэгдсэн стандарттай байх нь зөв гэж үзэж байна. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай харилцах заалтыг хэрэгжүүлэх замаар ЗДТГ-т байрлаж буй салбаруудыг тухайн орон нутгаас дэмжиж ажиллах, ачаалал нэмэгдэж буйтай холбоотой өрөөг томсгох, уулзалтын өрөөтэй болгох зэрэг шаардлагууд бий болж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангахад төрийн болон бусад байгууллагын

хамтын ажиллагаа чухал бөгөөд олон нийтийн статус бүхий МХХ, МӨХ зэрэг байгууллага өмнөх туршлага, хамтын ажиллагаагаа шинэ шатанд гарган улсын өмгөөлөгчийг мэргэшин ажиллахад чиглэсэн хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөр боловсруулан, сургалт зохион байгуулахад нь хамтарч ажиллах, түүнчлэн хувийн өмгөөлөгчийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх ажлын төрөл, үр дүнг хамтран таниулах, иргэн үйлчлүүлэгчийн өмгөөлүүлэх эрхийг хангахад хамтран дэмжлэг үзүүлэх зэрэг ажлыг үе шаттай хамтран зохион байгуулах нь чухал байна. ХЗТТ ч энэ асуудлыг соргогоор мэдэрч хамтран ажиллах Санамж бичгийг эдгээр байгууллагуудтай байгуулсан байгаа нь сайшаалтай.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгад эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх чиг үүргийг ХЗТТ-ийн туслалцаа үзүүлэх ажлын нэг төрөл байхаар хуульчилсан. Энэхүү ажлыг ХЗДХЯ-ны харьяа агентлаг, байгууллагуудтай чиг үүргийн уялдаа холбоог хангаж, хамтатган зохион байгуулж хэвших шаардлагатай байна. Түүнчлэн тус тусдаа төсөв бүхий хууль тогтоомж сурталчлах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ирсэн нь тухайн байгууллагын тайланд тусгагдаж, үр нөлөөг нь үнэлэх боломжгүй үлддэг байдлаас татгалзаж, хамтын оролцооны хэлбэрт шилжүүлэн үнэлгээжүүлэх, тухайн үнэлгээнд тулгуурлах төлөвлөлт хийж улсын хэмжээнд тухайн чиг үүрэгт хамаарах ажлыг бүрэн хүргэдэг үр дүнтэй хамтын ажиллагаанд шилжих нь зүйтэй гэж дүгнэж байна. Үүний зэрэгцээ мэдээлэл, сурталчилгааны ажлын хүртээмж, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт тогтоох, мэдээлэл авсан иргэд, байгууллагуудтай эргэх холбоо тогтоох ажлуудыг туршин сайжруулах нь зүйтэй.

Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгч болон хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллөөс тухайн жилийн ХЗТТ-ийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчийн үйлчилгээг үнэлүүлэхэд нийт 20 үзүүлэлтийн дунджаар 80.3 хувьтай үнэлэгдэж байна.

№	Үнэлгээ	Хувь /1-100%/	Оноо/1-5/
1	Иргэд, үйлчлүүлэгчдийн үнэлгээ	93.7	4.6
2	Хамтын ажиллагаа бүхий байгууллагын үнэлгээ	66.9	3.3
3	Дундаж	80.3	4.0

Хууль зүйн туслалцааны төв нь өмнөх 2021 онд гүйцэтгүүлсэн хэрэглэгчийн үнэлгээний зөвлөмжийн дагуу Хуулийн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан байгууллагынхаа бүтэц орон тоог шинээр батлах, цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах ажлыг төлөвлөн холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэн 2023 оны эхний улирлаас эхлэн хуулийн биелэлтийг бүрэн ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Гэвч өмнөх оны зөвлөмжүүдээс мэдээлэл, сурталчилгааны ажлыг иргэдийн орлогын түвшинтэй уялдуулан хийх, улсын өмгөөлөгчдийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор бүсчилсэн зөвлөгөө, хэлэлцүүлэг зохион байгуулж байх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор баг, хорооны нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллах гэсэн гурван зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь ажиглагдлаа. Цаашид хэрэглэгчийн үнэлгээний судалгаанаас гарсан зөвлөмжүүдийг боломжит байдлаар хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

## ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд тулгуурлан ХЗТТ-ийн хамтын ажиллагаа, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн дараахь зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Улсын өмгөөлөгчийн албан тушаалын статусыг тодорхой болгох, мөн ажлын ачааллыг харгалзан өмгөөлөгчийн орон тоог нэмэх, цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах;
2. Улсын өмгөөлөгчийн ажиллах орчныг сайжруулах, орон байрны хүрэлцээ, техник хэрэгсэл зэргийг сайжруулахад анхаарах;
3. Хамтын ажиллагаа бүхий байгууллагын ажилтан, албан хаагчдад ХЗТТ-ийн чиг үүрэг, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдээлэл, сурталчилгаа, сургалт хийх;
4. ХЗТТ-ийн хууль зүйн туслалцаа үзүүлж буй төрөл, хэлбэрийн талаар мэдээлэл сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээх;
5. Цагдан хорих ангид буй сэжигтэн, яллагдагчаас ирүүлсэн улсын өмгөөлөгч авах хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч хэвших, тухайн өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт, цохолтыг бүрэн цахимжуулах;
6. Цагдан хорих ангид буй сэжигтэн, яллагдагчтай улсын өмгөөлөгч очиж уулзах давтамжийг стандартчилах;
7. Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр Хууль зүйн яамны харьяа агентлаг, газруудын хамтын ажиллагааг сайжруулж, эрх зүйн шинэтгэлийн хоёр дахь үе шатыг эхлүүлэх, амжилттай хэрэгжүүлэхэд төрийн болон олон нийтийн байгууллагын хамтын ажиллагаа, төрийн байгууллага хоорондын нийтлэг чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлаа нэгтгэн хөтөлбөржүүлж, ажлын болон төсвийн давхцалгүй, үр дүнтэй байхаар төлөвлөн хэрэгжүүлэх;
8. Гадагш буюу иргэд, хамтран ажиллагч байгууллагуудад чиглэсэн ажлуудад илүү ач холбогдол өгч байх;
9. Академик судалгаа, шинжилгээний үйл ажиллагаанд гадаад, дотоод хамтын ажиллагааг чиглүүлэх.

-оОо-

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Үндсэн хууль
2. НҮБ-ын “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”
3. Төрийн албаны хууль
4. Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)
5. Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)
6. Өмгөөллийн тухай хууль
7. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
8. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг
9. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
10. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
11. Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”
12. МХХ-ны Зөвлөлийн 2014 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам”
13. МӨХ-ны Удирдах зөвлөлийн 2021 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Мэргэшлийн хорооны ажиллах журам”
14. ХЗТТ-ийн 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан
15. Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөө, хэрэгжилт 2022